



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/251

Сүхбаатар сум

### “Соёлын цаг” аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Соёлын тухай хуулийн 14.2.3, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16.1.1, Монгол Улсын Засгийн газрын “Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2020 оны 30 дугаар тогтоолын 11 дүгээр заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2020 оны А/43 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Орон нутгийн иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Соёлын цаг” аяныг 2020 оны 09 дүгээр сарын 01-нээс 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. “Соёлын цаг” нөлөөллийн аяныг орон нутагт зохион байгуулах хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

3. Сум орон нутагтаа Соёл, урлагийн газрын даргын 2020 оны А/43 дугаар тушаалаар батлагдсан зөвлөмж, батлагдсан хөтөлбөрийн дагуу “Орон нутгийн иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг ойртуулахад чиглэсэн урлаг, уран сайхан, номын сан, музей, орон нутаг сурталчлах танхимын явуулын үйлчилгээ, хүүхэд залуучуудад зориулсан тусгай арга хэмжээг /флаш моб, тик ток/ зохион байгуулахыг сумдын Засаг дарга, соёл, урлагийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

4. Аян зохион байгуулсан тухай тайланг 2020 оны 10 дугаар сарын 25-ны дотор аймгийн Боловсрол, соёл, урлагийн газарт хүргүүлэхийг соёл, урлагийн байгууллагын дарга эрхлэгч нарт, аяныг зохион байгуулахад хяналт тавьж, тайланг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /Ч.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ




Ж.САЙНЦОГ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430691321

Аймгийн Засаг даргын  
2020 оны 09 сарын 10 -ны өдрийн  
А/251 дүгээр захирамжийн хавсралт



**“СОЁЛЫН ЦАГ” НӨЛӨӨЛЛИЙН АЯНЫ ХӨТӨЛБӨР**

2020.09.07

Сүхбаатар сум

**НЭГ. ЗОРИЛГО:**

Иргэдэд соёл, урлагийн үйлчилгээ ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэхэд оршино.

**ХОЁР. ХУГАЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ**

Аймгийн 17 сум 6 тосгонд 26 соёл, урлагийн байгууллага 2020 оны 09 сарын 01-нээс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл зохион байгуулна.

**ГУРАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

№	Зохион байгуулах ажил	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
1	“Соёлын цаг” нөлөөллийн аяны нээлтийн арга хэмжээ	2020.09.10 15:00-17:00 Партизаны талбайд	АДБ-н Сэлэнгийн долгио чуулга, Сүхбаатар сум дахь аймгийн Нийтийн номын сан, Нэгдсэн музей
2	Музейтэй өдөр	2020.09.18 Партизаны талбайд	Нэгдсэн музей
3	Номын сантай өдөр	2020.09.21 Партизаны талбайд	Сүхбаатар сум дахь аймгийн Нийтийн номын сан
4	Алслагдсан багийн иргэдэд үзүүлэх соёл, урлагийн цогц үйлчилгээ-1	2020.09.25 Сүхбаатар сумын 1-р багт	АДБ-н Сэлэнгийн долгио чуулга, Сүхбаатар сум дахь аймгийн Нийтийн номын сан, Нэгдсэн музей
5	Алслагдсан багийн иргэдэд үзүүлэх соёл, урлагийн цогц үйлчилгээ-2	2020.10.02 Сүхбаатар сумын 5-р багт	
6	Алслагдсан багийн иргэдэд үзүүлэх соёл, урлагийн цогц үйлчилгээ-3	2020.10.09 Сүхбаатар сумын 4-р багт	
7	Сумдын иргэдэд соёл, урлагийн цогц үйлчилгээ үзүүлэх	2020.09.01-10.20 аймгийн 17 сум 5 тосгон	Сумдын 19 соёлын төв, 1 соёлын ордон
8	“Соёлын цаг” нөлөөллийн аяны хаалтын арга хэмжээ	2020.10.17, 20 дуу бүжгийн Мөнгөн хараа чуулгын байранд	Дуу бүжгийн Мөнгөн хараа чуулга, Мандал сум дахь аймгийн Нийтийн номын сан

-----000-----